



НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2024 оны 02 сарын 28 өдөр

Дугаар 28

Улаанбаатар хот

Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгч
орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн
зарим газрыг өөрчлөн байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлд 18.2, 18.3 дахь хэсэг, 35 дугаар зүйлийн 35.1.12 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалт, Монгол Улсын Иргэний хуулийн 31 дүгээр зүйл, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 50 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. “Зорчигч тээвэр нэг”, “Зорчигч тээвэр хоёр”, “Зорчигч тээвэр гурав”, “Зорчигч тээвэр дөрөв”, “Зорчигч тээвэр тав” нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгч орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрыг тус тус 2024 оны II улиралд багтаан байгуулсугай.

2. “Зорчигч тээврийн нэгтгэл”, “Зорчигч тээвэр гурав” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрыг 2024 оны II улиралд багтаан татан буулгаж, эрх үүрэг хариуцлагыг тогтоолын 1-д заасан аж ахуйн тооцоот үйлдвэрийн газарт шилжүүлсүгэй.

3. Энэ тогтоолын 1-д заасан орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дүрмийг 1-5 дугаар хавсралт ёсоор баталсугай.

3.1. “Зорчигч тээврийн нэгтгэл” ОНӨААТҮГ-ын Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд “Зорчигч тээвэр нэг”, “Зорчигч тээвэр хоёр” ОНӨААТҮГ-ын Удирдах зөвлөлийг шинээр томилогдох хүртэл хугацаанд үүрэг гүйцэтгүүлэх эрхийг олгосугай.

3.2. “Зорчигч тээвэр гурав” ОНӨААТҮГ-ын Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд “Зорчигч тээвэр гурав”, “Зорчигч тээвэр дөрөв”, “Зорчигч тээвэр тав” ОНӨААТҮГ-ын Удирдах зөвлөлийг шинээр томилогдох хүртэл хугацаанд үүрэг гүйцэтгүүлэх эрхийг олгосугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан дараах арга хэмжээ авахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Х.Нямбаатар)-д даалгасугай.

4.1. Зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгч орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын хөрөнгөд бүртгэлтэй эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгөөс балансаас балансад шилжүүлэх, хөрөнгийн асуудлыг шийдвэрлэж, хөрөнгийн эх үүсвэрийн хамт авлага, өр төлбөрийг тооцон шилжүүлэх ажлыг зохион байгуулах;

4.2. Зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгч орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын бүтэц, орон тоог тогтоож, удирдлагыг томилох;

111 1.07.24

4.3.Шинээр байгуулагдсан зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгч орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрыг улсын бүртгэлд бүртгүүлэх;

4.4.Зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгч орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын зорилтот түвшинг баталж, ажил үйлчилгээг хэвийн хэмжээнд явуулах, өмч хөрөнгийн хөдөлгөөн, ашиглалтад хяналт тавьж ажиллах;

5.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын Засаглал, эрх зүйн шинэтгэлийн хороо (Н.Баярчимэг)-нд даалгасугай.

ДАРГА



Ж.БАТБАЯСГАЛАН

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн
28 дугаар тогтоолын дөрөвдүгээр хавсралт

“ЗОРЧИГЧ ТЭЭВЭР ДӨРӨВ” ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. “Зорчигч тээвэр дөрөв” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар /цаашид ОНӨААТҮГ гэх/ нь өөрийн балансад бүртгэгдсэн эд хөрөнгө, энэхүү дүрмээр хүлээсэн эрх, үүргийн хүрээнд улс, орон нутгийн төсвөөс олгогдсон хөрөнгө оруулалтаар болон бусад үйл ажиллагааны орлогоор санхүүжих замаар бие даан иргэний гүйлгээнд ордог нийтийн тээврийн хэрэгслээр зорчих, үйлчлүүлэх эрэлт, хэрэгцээг хангах орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар мөн.

1.2. “Зорчигч тээвэр дөрөв” ОНӨААТҮГ (цаашид “газар” гэх) нь үйл ажиллагаандаа Монгол Улсын “Үндсэн хууль, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай, Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Компанийн тухай, Авто тээврийн тухай хуулиуд болон Монгол Улсын бусад холбогдох хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Засаг даргын захирамж, мөрийн хөтөлбөр, Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн тушаал болон энэхүү дүрмийн хүрээнд үйл ажиллагаа явуулна.

1.3. Газрын дүрмийн зорилго нь өөрийн үйл ажиллагааны үндсэн чиг үүргийг тогтоох, удирдлага, зохион байгуулалтын бүтэц, хяналт, үйлдвэрийн газрын эд хөрөнгийн эрх, түүнийг өөрчлөн байгуулах, бүртгүүлэх зэрэгтэй холбогдох үйл ажиллагааны харилцааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохицуулахад оршино.

1.4. “Зорчигч тээвэр дөрөв” ОНӨААТҮГ-ын өмчлөгч нь Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал байх бөгөөд төлөөлөл хэрэгжүүлэгч нь Нийслэлийн Засаг даргаас эрх олгосон нийслэлийн захиргааны байгууллага болох Өмчийн харилцааны газар байна.

Хоёр. Газрын оноосон нэр, оршин байгаа газар

2.1. Газрын оноосон бүрэн нэр нь “Зорчигч тээвэр дөрөв” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар байх ба товчилсон нэр нь “Зорчигч тээвэр 4” ОНӨААТҮГ байна.

2.2. Удирдах газрын оршин байгаа газар, шуудангийн хаяг, электрон шуудангийн хаяг, харилцах утасны дугаар тодорхой байна.

Гурав. “Зорчигч тээвэр дөрөв” ОНӨААТҮГ-ын бэлгэдэл, тэмдэг

3.1. Газар нь өөрийн бэлгэдэл, барааны тэмдэгтэй байхаас гадна албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэг хэрэглэнэ. Газрын нэгж нь салбарын хэвлэмэл хуудас тэмдэг хэрэглэж болно.

3.2. Бэлгэдэл барааны тэмдгийн загварыг Захирал баталж, Оюуны өмчийн газарт бүртгүүлсэн байх бөгөөд ОНӨААТҮГ хэрэглэнэ.

3.3. Тэмдгээр үйлдвэрийн газрын албан ёсны шийдвэр, алба бичиг, гэрээ хэлцлийг баталгаажуулна.

3.4. Тэмдгийг үйлдвэрийн газрын Захирлаас итгэмжлэн хариуцуулсан албан тушаалтан түшиж, ашиглалт, хамгаалалт, хадгалалтыг хариуцна.

Дөрөв. “Зорчигч тээвэр дөрөв” ОНӨААТҮГ-ын зорилго, үйл ажиллагааны үндсэн чиглэл

4.1. Газрын зорилго нь нийслэлийн иргэд, зорчигчдын нийтийн зорчигч тээврийн үйлчилгээг орчин үеийн түвшинд хүргэж хөгжүүлэх чанар, үр дүнг дээшлүүлэх, иргэдэд шуурхай, боловсон ая тухай үйлчлэх, хөрөнгө оруулалтын үр дүнг дээшлүүлэх, үйлчилгээний

менежментийг сайжруулах төсөл хэрэгжүүлэх, хэтийн төлөвийг тодорхойлох замаар Улаанбаатар хотын нийтийн тээврийн үйлчилгээг олон улсын жишигт хүргэхэд оршино.

4.2.Нийслэл Улаанбаатар хотод нийтийн тээврийн үйлчилгээг эрх бүхий байгууллагаас тогтоосон чиглэлийн замнал, хөдөлгөөний цагийн хуваарийн дагуу үзүүлж, өдөр тутмын үйл ажиллагааг "Зорчигч тээвэр дөрөв" ОНӨААТҮГ-ын удирдлага зохион байгуулна.

4.3.Газар нь дараах үйл ажиллагааны үндсэн чиглэл: Нийтийн тээврийн үйлчилгээний стандартыг мөрдөж, үйлчилгээний ёс зүйн хэм, хэмжээ, хууль тогтоомж, дүрэм, журмыг чанд баримтлан үйл ажиллагааны хувьд ашигтай ажиллах болно. Үүнд:

4.3.1.Нийслэлийн иргэдэд нийтийн зорчигч тээврийн үйлчилгээг тав тухтай, аюулгүй байдлыг хангасан нийтийн тээврийн хэрэгслээр хүргэх;

4.3.2.Нийтийн зорчигч тээврийн хэрэгслүүдэд хийх их болон урсгал засварын нэгдсэн төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх, ашиглалтад хяналт тавих;

4.3.3.Нийтийн зорчигч тээврийн үйл ажиллагаа явуулахад шаардагдах хүний нөөц (инженер, мэргэшсэн жолооч, засварчин)-ийг бэлтгэх, мэргэжил боловсролыг дээшлүүлэх чиглэлээр сургалтын үйл ажиллагаа явуулах;

4.3.4.Улаанбаатар хотын нийтийн тээвэрт орчин үеийн дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх, ашиглалтын ажлыг удирдан зохион байгуулж гүйцэтгэлд хянах.

4.4.Газар нь гадаад, дотоодын холбогдох байгууллагуудтай зохих журмын дагуу харилцаа холбоо тогтоож, хамтран ажиллах, үйл ажиллагааны төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, хууль тогтоомжоор хориглоогүй бусад үйл ажиллагааг эрхлэх, түүнчлэн шүүх эрх мэдлийн болон мөрдөн шалгах, хууль сахиулах байгууллагад иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагчаар оролцоно.

4.5.Газар нь байгууллагын чадавхыг хөгжүүлэх, материаллаг баазыг бэхжүүлэх, нийтийн тээврийг шинэчлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж ажиллана.

4.6.Газар нь нийтийн зорчигч тээврийн үйлчилгээг дэлхийн ижил төстэй хотуудын түвшинд хүргэх, үйлчилгээний стандарт, тээвэрлэлтийн норм, дүрэм, аюулгүй ажиллагааны дүрмийг мөрдөж ажиллах үүргийг хүлээнэ.

4.7.Нийслэлийн Засаг даргад үйлчилгээний хөлс, үнэ тарифыг шинэчлэх хэрэгцээ, шаардлагыг тодорхойлсон танилцуулга, мэдээлэл, санал хүргүүлнэ.

4.8.Үйлдвэрийн газар нь үйлдвэрлэлийн болон нийтийн тээврийн үйлчилгээний материаллаг баазыг өргөтгөх, орчин үеийн дэвшилтэт, шинэ техник технологийг нэвтрүүлэх, хүчин чадлыг нь бүрэн ашигласан үйлдвэрлэл, үйлчилгээ явуулна.

4.9.Газар нь өөрийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал, Нийслэлийн Засаг даргын захирамжаар гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх, гүйцэтгэлд нь хяналт тавих ажлыг зохион байгуулна.

Тав. Газрын эд хөрөнгийн эрх

5.1. Газар нь өөрийн эзэмшиж байгаа эд хөрөнгийн талаар хуульд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

5.2.Газар нь эд хөрөнгийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

5.2.1.Өөрт олгогдсон үл хөдлөх хөрөнгийг дүрэмд заасан үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн эзэмших, ашиглах;

5.2.2.Эргэлтийн бус хөрөнгийг нийслэлийн Өмчийн харилцааны газартай байгуулсан гэрээгээр олгосон эрх хэмжээний дотор захиран зарцуулах;

5.2.3.Үйл ажиллагааны үр дүнд олсон ашгаас хуульд заагдсан татвар, хураамжийг төлсний дараах цэвэр ашгаас эрх бүхий байгууллагаас тогтоосон ногдол ашгийг төсөвт төвлөрүүлж үлдэх хэсгийг зохих журмын дагуу захиран зарцуулах;

5.2.4.Ажил үйлчилгээ үзүүлсний үр дүнд олсон ашгийг эрх бүхий байгууллагаас тогтоосон норматив хэмжээгээр үлдээж хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах;

5.2.5.Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд зааснаар нийтийн тээврийг хөгжүүлэх санд орлого төвлөрүүлэх;

5.2.6.Нийслэлийн нийтийн тээврийн талаарх бодлого шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, байгууллагаас гаргасан эд хөрөнгийн харилцаатай холбоотой үүрэг даалгавар, шийдвэрийн биелэлтийг хангах;

5.3.Газар эргэлтийн бус хөрөнгийг нь зөвхөн Өмчийн харилцааны газрын шийдвэрийг үндэслэн олж авах, акталж данснаас хасах, худалдан борлуулах, устгах, шилжүүлэх эрхтэй.

Зургаа. Газрын удирдлага, удирдах зөвлөл

6.1.Газар нь Удирдах зөвлөлтэй байж болно. Удирдах зөвлөл нь Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 54 дүгээр тогтоолоор баталсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн Удирдах зөвлөлийн ажиллах журам"-д заасны дагуу үйл ажиллагаагаа явуулна.

6.2.Газрын өдөр тутмын үйл ажиллагааг захирал удирдана. Захирлыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч томилж, чөлөөлнө.

6.3.Захирал нь Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасан шалгуурыг хангасан байна.

6.4.Захирал нь орон нутгийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлд орох, тэдгээрийн захиргаанд буюу олон нийтийн болон шашны байгууллага, сангийн удирдах ажлыг хавсран гүйцэтгэхийг хориглоно.

6.5.Захиралд зөвлөх үүрэг бүхий даргын зөвлөл ажиллана. Зөвлөлийн гишүүд нь захиралд зөвлөх эрхтэй ба бүрэлдэхүүн, ажиллах журмыг захирал батална.

6.6.Захирал нь дор дурдсан эрх, үүрэгтэй байна.

6.6.1.Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд газрын дүрэм, зорилтын санал, бизнес төлөвлөгөөг батлуулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг хангуулах;

6.6.2.Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх, удирдаж буй газрын хэвийн үйл ажиллагааг хангасны үндсэн дээр санхүү, төлбөрийн чадвар, нэр хүндийг бүх талаар дээшлүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагаа явуулах;

6.6.3. Газрын эрх ашгийг дээдэлж, мэргэжил, ажлын дадлага, туршлагаа бүрэн дайчлан ажиллах;

6.6.4.Ажил үүргээ гүйцэтгэх явцад олж авсан үйл ажиллагааны болон бизнесийн нууцын чанд хадгалах, хувийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхолд нийцүүлэн ашиглахгүй байх;

6.6.5.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчаас баталсан удирдлагын бүтэц, зохион байгуулалтын хүрээнд ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг батлах, ажилтныг ажилд томилох, тэдэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулах, цалингийн хэмжээ, урамшууллын журмыг тогтоох, хууль тогтоомжийн хүрээнд ажлаас чөлөөлөх;

6.6.6.Захирлын эдлэх эрх, хүлээх хариуцлага, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, цалин хөлс, урамшуулал зэрэг асуудлыг хөдөлмөрийн гэрээнд тусгана.

6.6.7.Хууль тогтоомж болон гэрээгээр олгосон бусад эрх үүрэг

6.7.Захирал нь Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч, Өмчийн харилцааны газраас олгосон эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах, удирдах газрыг төлөөлөх зэргээр удирдах газрын нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулна.

6.8.Захирал нь холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу эрх хэмжээнийхээ хүрээнд тушаал гаргана.

6.9.Захирал өөрийн эрх, үүргийг Өмчийн харилцааны газрын даргатай зөвшилцөн итгэмжлэлийн үндсэн дээр холбогдох алба тушаалтанд түр шилжүүлж болно. Ийнхүү эрхээ итгэмжлэн шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

Долоо. Газрын хяналт

7.1.Газар нь үндсэн болон санхүүгийн үйл ажиллагааг хянах дотоод хяналттай байна. Дотоод хяналтын бүтэц, журмыг захирал батална.

7.2.Холбогдох хууль тогтоомж, журмын дагуу үйлдвэрийн газрын үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагаанд хөндлөнгийн аудитын байгууллагын дүгнэлт гаргуулна.

7.3.Нийслэлийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, хадгалалт, хамгаалалт, ашиглалт болон санхүүгийн үйл ажиллагаанд Өмчийн харилцааны газар хяналт тавьж ажиллана.

7.4.Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг ерөнхий нягтлан бодогч хариуцан хэрэгжүүлнэ.

Найм. Газрын санхүү, бүртгэл, тайлан

8.1.Газар нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомж, Олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу жил бүр гаргаж, аудитын байгууллагаар дүгнэлт гаргуулна.

8.2.Газрын санхүүгийн тайлангийн үнэн зөвийг Захирал, Ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.

8.3.Газрын ерөнхий нягтлан бодогч нь мэргэшсэн нягтлан бодогч байх бөгөөд мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан байна.

8.4.Газрын санхүүгийн жил нь тухай оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхэлж, мөн оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болно.

Ес. Газрын санхүүжилт, санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан

9.1.Газрын орлого нь дараах санхүүгийн эх үүсвэрээс бүрдэнэ:

9.1.1.Улсын болон нийслэлийн төсвийн санхүүжилт

9.1.2.Ажил үйлчилгээнээс олсон бүх орлого

9.1.3.Байгууллагатай хамтарч ажиллах гэрээний дагуу олсон үйлчилгээний орлого

9.1.4. Хандивлагч орнуудын зээл, тусламж болон буцалтгүй тусламж

9.1.5. Хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөн бусад эх үүсвэр

9.2.Газрын санхүүгийн тайланд дараах зүйлийг тусгана.

9.2.1.Баланс

9.2.2.Үйл ажиллагааны үр дүнгийн тайлан

9.2.3.Мөнгөн гүйлгээний тайлан

9.2.4.Өмчийн өөрчлөлтийн тайлан

9.2.5.Тухайн тайлангийн хугацаанд хийгдсэн их хэмжээний болон сонирхлын зөрчил бүхий хэлцлийн жагсаалт, нэр төрөл, үнийн дүн, удирдлагад олгосон цалин, шагнал урамшуулал

9.2.6.Нэмэлт тайлбар

9.2.7.Санхүүгийн тайлангийн тодруулга

9.2.8.Бусад

9.3.Захирал нь Өмчийн харилцааны газарт тухайн жилийн үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалт, зарцуулсан хөрөнгө, санхүү, үр дүнгийн талаар тодорхой тусгасан тайлан, илтгэх бичиг хүргүүлэх бөгөөд тайланд дараах зүйлийн тусгана.

9.3.1.Тайлангийн хугацаанд удирдах газрын эрхлэн явуулсан үндсэн үйл ажиллагааны талаарх танилцуулга, гарсан өөрчлөлтүүд болон эдгээр үйл ажиллагааны үр дүнгийн байдал, түүний өөрчлөлт

9.3.2.Тайлангийн хугацаанд удирдах газрын албан тушаалтан, ажиллагсдад олгосон шагнал, урамшил, удирдлагын зардлын хэмжээ

9.4.Шаардлагатай бусад мэдээлэл

Арав. Газрын баримт бичгийг хадгалах

10.1.Газар нь дараах баримт бичгийг хадгална:

10.1.1.Газрын дүрэм, дүрэмд орсон нэмэлт өөрчлөлттэй холбогдох газруудын шийдвэр, тогтоол, улсын бүртгэлийн гэрчилгээ болон бусад гэрчилгээ сертификатууд



10.1.2. Санхүүгийн үйл ажиллагааны тайлангууд, түүнд хийгдсэн аудитын дүгнэлт, зөвлөмжүүд

10.1.3. Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн баримтууд, түүнд тусгагдсан эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийг нотлох баримтууд

10.1.4. Үйлдвэрлэл, технологи, норм, нормативууд түүнтэй холбогдох дүрэм, журам, зааврууд, бусад баримт бичиг

10.1.5. Хурлын тэмдэглэл, шийдвэр, захирлын гаргасан тушаал, шийдвэрүүд

10.1.6. Тухайн байгууллагын ирсэн, явуулсан баримт бичиг

10.1.7. Тухайн байгууллагын хөтлөх хэргийн жагсаалтын дагуух ач холбогдол бүхий баримт бичгүүд

10.2. Дээрх баримт бичгийг зохих журмын дагуу холбогдох этгээдээс хүлээн авч хадгалах, эрх бүхий этгээдэд танилцуулах, архивд шилжүүлэх зэрэг ажлыг захирлын туслах, бичиг хэргийн ажилтан эрхлэн гүйцэтгэнэ.

Арван нэг. Үйлдвэрийн газрын татан буулгах

11.1. Газрыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн саналаар Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал өөрчлөх, татан буулгах асуудлыг шийдвэрлэнэ.

Арван хоёр. Хариуцлага

12.1. Монгол улсын хууль тогтоомж, Нийслэлийн ИТХ-ын тогтоол, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн захирамжийн биелэлтийг хэрэгжүүлэх явцад буруу шийдвэр гаргаж бусдад хохирол учруулсан нь шүүхээр тогтоогдсон бол холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.

12.2. Захирал нь эрх мэдлээ хэтрүүлэх буюу урвуулан ашиглаж байгууллагад хохирол учруулсан бол хохирлыг байгууллагын захирал өөрийн хувийн өмчийн эд хөрөнгөөр бүрэн хариуцна.

12.3. Захирал нь Монгол улсын хууль тогтоомж, онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчвөл хариуцлага хүлээнэ.

Арван гурав. Бусад

13.1. Хуульд нийцүүлэн дүрэмд тусгаснаас бусад асуудлыг хуулиар зохицуулна.

13.2. Газрын энэхүү дүрэм нь Монгол улсын Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт бүртгэгдсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

